



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 24 өдөр

Дугаар A/50


Улаанбаатар хот

Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 7 дахь хэсгийн 7.7.3, тус газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баянгол дүүргийн Засаг даргын 03/1270 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн тус дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэр 36-17 тоотод үйл ажиллагаа явуулдаг Ай эм ай трейвел ХХК-ийн “Анарс” дэн буудлын / зөвшөөрлийн дугаар 19/72 / үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосугай.
2. Зөвшөөрлийг хураан авч харъяалах дүүргийн Цагдаагийн хэлтэст мэдэгдэхийг Захиргааны хэлтэс /Д. Ганболд/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТСҮХ